



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж,
хариуцлага үр дүнг тооцох жил” болгон зарлах тухай

Иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх Зам, тээврийн салбарын үйлчилгээг бүрэн цахимжуулж, ил тод, нээлттэй, шуурхай, хүртээмжтэй болгох, эдийн засгийн өсөлтийг хангасан аюулгүй, найдвартай тээврийн дэд бүтцийг хөгжүүлж, салбарын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

1. Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023 оныг “Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил” болгон зарласугай.
2. “Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллага, салбарын төрийн өмчийн компаниудын дарга, захирал нарт дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:
 - 2.1. Цахимжуулах үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээг тогтоон, шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлон бүрэн цахимжуулж ил тод нээлттэй, шуурхай, хүртээмжтэй чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх;
 - 2.2. Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, бүх төрлийн тээврийн ачаа, зорчигч тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулахад онцгой анхаарч ажиллах;
 - 2.3. Бүх шатанд ажлын цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг үнэлэх, урамшуулах, хариуцлага тооцох, тайлагнах тогтолцоог боловсронгуй болгож үйл ажиллагаандаа хэвшүүлэх;
 - 2.4. “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-ыг үйл ажиллагаандаа ашиглаж, байгууллагын дотоод мэдээллийн системүүдээс шаардлагатай өгөгдлийг бодит цагийн горим /RealTime/-оор солилцох боломжийг хангаж ажиллах;
 - 2.5. Харьяа байгууллага, салбарын төрийн өмчит компани, төсөл хэрэгжүүлэгчид ажлаа сар бүр нарийвчлан төлөвлөж, хэрэгжилтийг

080000002

хангуулах, гүйцэтгэлийн тайлан мэдээг ЗТХЯ-нд тогтоосон хугацаанд цахимаар тайлагнах;

- 2.6. Төрийн хэмнэлтийн хуулийг чанд мөрдөн ажиллах, орон тооны хязгаарыг нэмэхгүй байх, тэвчиж болох зардлыг хязгаарлах, харьяа байгууллага бүр байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, ажлын байрны давхардлыг арилгах, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг сайжруулж шинэчлэн батлуулах арга хэмжээ авах;
 - 2.7. Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлан мэдээ, ажлын явцын мэдээллийг зам, тээврийн салбарын төслийн мэдээллийн программ /projects.mrtf.gov.mn/-ыг ашиглан сар бүр тайлагнах;
 - 2.8. Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шинэ техник, технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
 - 2.9. Бүтээмжийг нэмэгдүүлэх шинэ санаа, шийдлийн талаар судалгаа хийх, ажилчдын дунд уралдаан зарлах, шалгарсан санал, шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, урамшуулах, үр дүн гарч, бүтээмж нэмэгдэж байгаа сайн туршлагыг сурталчлан таниулах, бусад байгууллагад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 2.10. Бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын байрны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, байгууллагын соёлын шинэ орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байрны бүх хэлбэрийн дарамт, шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоох ажлыг зохион байгуулах, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;
3. "Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох" жилийн хүрээнд хийх ажлын нэгдсэн төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг улирал тутамд Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнах, гарсан үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг харьяа байгууллага, салбарын төрийн өмчийн компаниудын дарга, захирал нарт үүрэг болгосугай;
 4. Салбарын байгууллагын сахилга, хариуцлага, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор тэнгэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг салбарын байгууллагуудад тогтмол зохион байгуулахыг Зам тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газар /Д.Энх-Амгалан/-т даалгасугай.
 5. Өнэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг улирал тутам танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар /А.Мөнхбат/-т үүрэг болгосугай.

